

**ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН,  
ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ.**

1. Нэмэлт санхүүжилтийн данснаас 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдөр анхан шатны баримтгүйгээр сум хөгжүүлэх сангийн төрийн сан дахь 040355401 дугаартай дансанд 10000.0 /Арван сая төгрөг/ мянган төгрөгийг, мөн оны 11 дүгээр сарын 10-ны өдөр анхан шатны баримтгүйгээр 1000.0 /Нэг сая төгрөг/ мянган төгрөгийг тэмцээний зардалд гэж гарган 2016 оны жилийн эцсийн тайлан балансад дээрх үндсэн баримгүй зарцуулсан 11000.0 мянган төгрөгийг зардлын дансанд бүртгэж авлагаар тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 /анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/14 дүгээр зүйлийн 14.4 /Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ./ 14.4.2-д /бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага/ дэх заалтыг зөрчсөн мөн 2016 оны 12 дугаар сарын 21-д нярав асан Саранчимэгийн ХААН банкин дахь 5274023177 дансанд ХХОАТ-ын 267100 төгрөгийг шилжүүлсэн ч төсвийн орлогын дансанд төвлөрүүлээгүй байна.

2. Бүрэгхангай сумын ЗДТГ-т МОНЦЕМЕНТ БИЛДИНГ МАТЕРИАЛС ХХК-ийн ПОРТЛАНД ЦЕМЕНТ ОРС 42.5 нэртэй 30 /Гучин тн/ 30 тн цементийг уурхайн дарга, инженер, жолооч нар хүлээлгэн өгч, ЗДО Ё.Баяр, БОХУБ Г.Батжүгдэр, ня-бо Б.Энхцэцэг, нярав Д.Саранчимэг нар акт үйлдэн хүлээн авсан ч зөвшөөрлийн бичгээр 430 уут цементийг олгосон ба 170 уут цементийг зөвшөөрөлгүйгээр олгосон байна. Нийт 600 уут буюу 30 тн цементийг орлогод авч данс бүртгэлд тусгаагүй урсгалаар зарцуулсан байна.

3. Тайлан балансын малын тэжээл дансанд 19700.0 мянган төгрөгийн мал байсныг 2185.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2350.0 мянган төгрөгөөр хорогдуулж 19535.0 мянган төгрөгийн малын үлдэгдэлтэй тайлан гаргасан байна. Гэтэл туслах аж ахуйн тооцоо бодолтоор 21 ишгийг 210000 төгрөгөөр үнэлэн орлогод авч, 57 ямааг нас дэвшүүлсэн, захирамжаар 5 эр шүдлэн, 14 ямааг зарлага болгосон ба 18 ямаа үхсэн малын жагсаалтад оруулсан ч 13 ямааг зарлага болгосон нь 5 ямаа дутагдсан байна. Ямааны ноолурын үнэ 652.8 мянган төгрөгийг төрийн сан дахь 040355001 дансанд тушаасан байна. Хэдэн кг ноолуур авсан нь тодорхойгүй байна.

4. ИТХ нь 2016 оны 03 дугаар 25-ны өдрийн 0028 дугаартай төлбөрийн хүсэлтээр Улаанбаатар хотын Гурусофт ХХК-ны Голомт банкин дахь 1410007323 дугаар дансанд 300000 төгрөгийг байгууллагын архивын программын үнэ гэж шилжүүлсэн ч 2016 оны тайлан балансад бүртгээгүй,

5. 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 тоот төлбөрийн хүсэлтээр Б.Даваажаргалын ХААН банкин дахь 5274076152 дугаартай дансанд 71000 төгрөгийг анхан шатны баримтгүйгээр олгосон, 2016 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 73,74 дугаар төлбөр хүсэлтүүдээр нягтлан бодогч Энхцэцэг, Батцэцэг нарын ХААН банкин дахь харилцах дансдуудад тус бүр 100.0 мянган төгрөгийн буудлын

зардал шилжүүлэхдээ 1 хоногийн зардал 40000 төгрөгийг тус тус илүү шилжүүлсэн, 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 27 дугаартай төлбөрийн хүсэлтээр Засаг даргын нөөц сангаас Цэнгэлмаагийн ХААН банкин дахь 5274023280 дансанд шатахууны 65200 төгрөг, тэмцээнд оролцох эрхийн төлбөрт 60000 төгрөгийг шилжүүлсэн, 2016 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 39 дугаар төлбөрийн хүсэлтээр нярав Саранчимэгийн ХААН банкин дахь 52740233177 дансанд нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах зардалд 150000 төгрөг шилжүүлсэн ч зарцуулах эрхийн шийдвэргүй, 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 43 дугаар төлбөрийн хүсэлтээр Цэнгэлмаагийн ХААН банкин дахь 5274023280 дансанд 400000 төгрөгийг сурын харвааны насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцогчдын зардалд зарцуулах захирамж, 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 54 дугаар төлбөрийн хүсэлтээр Саранчимэгийн ХААН банкин дахь 5274023177 дансанд бэлэн мөнгө татах захирамжуудад тус тус Засаг даргын гарын үсэг, тамгагүй, 2016 оны 2016 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн Б/19 дүгээр захирамжаар багийн засаг дарга Б.Даваажаргал 76 оноогоор С үнэлгээтэй үнэлэгдсэн байхад 40 хувь, багийн Засаг дарга Л.Баттөгөлдөр 74.6 оноогоор С үнэлгээтэй байхад 40 хувь үндсэн цалингаас бодож олгох захирамж, 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн Б/35 дугаартай Тамгын газрын даргын тушаалаар МЭҮТ-ийн дарга Л.Ганболд 77.8 оноогоор С, мал зүйч Д.Наранцацралт 70 оноогоор С, санхүүгийн албаны дарга У.Ундармаа 70 оноогоор С, жолооч А.Чинбат 70 оноогоор С, авсан байхад 2016 оны ажлын үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гаргасан байна.

6. Анхан шатны баримтууд болох орлого зарлагын баримтуудыг дугаарлаагүй зэрэг зөрчлүүд гарлаа.

Дээрх зөрчлүүд нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн

#### АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ:

Дээрх зөрчлүүдээс үүдэлтэй үр ашиггүй зарцуулсан, ажилдаа хариуцлагагүй хандсныг холбогдуулан 2748383 төгрөгийн төлбөрийн акт тогтоож, улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, бараа материалын тайлан гаргах талаар

мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, анхан шатны баримтгүй зарцуулсан 10000.0 мянган төгрөгийн шалгалтын хугацаанд барагдууллаа.